



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 5/05

Хажуу шинэ үс

Нэргүйн Ганбатыг ажилд томилох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт, Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 5/483 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны нийтийн ерөнхий үйлчилгээ, сан хариуцсан нягтлан бодогчоор Нэргүйн Ганбатыг 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн томилсугай

2.Н.Ганбатыг ТҮ-8-1 зэрэглэл болох 700,895 (Долоон зуун мянга найман зуун ерэн таван төгрөг)-өөр цалинжуулахыг Санхүү албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэч (Э.Уранбилэг)-т зөвшөөрсүгэй.

3.Албан үүргээ гүйцэтгэхдээ Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хориглолт хязгаарлалтуудыг баримтлан, бусад хууль тогтоомж,ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэж эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандан,төрийн албан хаагчийн ёс зүй,санхүүгийн албаны чиг үүргийг хуулийн хүрээнд чанд сахин ажиллахыг (Н.Ганбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ӨЛЗИЙТОГТОХ